



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№85 /298/

2022.05.03

Цаг үе, үйл явдал

ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫГ УГТАЖ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохиогдох Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн чуулганыг угтаж, ХНХ-ын сайдын тушаалын дагуу "Ээлтэй орчин-Эрүүл ирээдүй" чуулган, нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдлаа. Уг чуулганы хүрээнд БХЯ-наас хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлаар хэлэлцүүлэг явуулсан юм. Арга хэмжээнд УИХ-ын гишүүн Б.Байрсайхан, БХЯ-ны ТЗУГ-

ын дарга хурандаа С.Ванчинхүү, ЗХЖШ-ын I орлогч дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал, ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Г.Батдорж болон албаны бусад хүмүүс оролцлоо. Мөн ХНХ-ын сайд А.Ариунзаяа цахимаар тус хэлэлцүүлэгт оролцож,

хүүхэд хамгааллын чиглэлээр явуулж байгаа БХЯ-ны бодлоготой танилцсан. Хэлэлцүүлгийн хүрээнд "Хүүхэд, залуучуудын гэр бүлийн хүмүүжил, төлөвшил цэргийн албанд нөлөөлж буй нь", "Хүүхдийн цахим орчны хэрэглээ ба эцэг, эхийн хяналт", "Гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхэд бидний оролцоо" сэдвийг багууд хуваан авч, өөрсдийн

санал, хүсэлт, тулгамдаж буй асуудлуудаа дэвшүүлсэн юм. Батлах хамгаалах салбарын алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, алслагдсан аймаг, орон нутагт ажиллаж буй алба хаагчдын хүүхдүүдийн сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулах шаардлага байгааг хэлэлцүүлгийн үеэр дурдаж байлаа.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 23	🌧️ 2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	🌧️ 25

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,105.00	3,115.0
EUR 🇪🇺	3,315.0	3,350.0
CNY 🇨🇳	465.00	471.00
RUB 🇷🇺	38.00	39.00
JPY 🇯🇵	24.00	25.00
KRW 🇰🇷	2.48	2.52

ЗУРХАЙ



2022.05.03 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 03/

ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААН ЛУУ ӨДӨР

Үс засуулбал: Эд мал баялаг төгөлдөр болно. **НАРАН УРГАХ, ШИНГЭХ:** 05.31-20.07 **Барилдлага:** Түлэх **Шүтэн барилдлага:** Сэрэхүй **Суудал:** Гал

Энэ өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмтнийг шийтгэх, угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлах, дархны үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Балжиннямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, малтай баялаг төгс болно.

БАГА НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ ТА БҮХЭН ХҮҮХЭДЭЭ ЗЭРТ ИЛРҮҮЛЭГТ ХАМРАЦЛАГААР!

0-5 НАС

ЭМЧИЙН ҮЗЭГТ
ӨСӨЛТӨЙН ҮНДЭЛЭЭ
ЗАН ТӨРХИЙН ҮНДЭЛЭЭ

АНХЫН ХӨХӨГЧ
ЭРҮҮЛ МЭНД

ШУДНЫ ҮЗЭГТ
ШҮД, УГААХ
АРГАЧИЛАЛ
ЭРҮҮЛ АХУЙН
ЗӨВЛӨГӨӨ

Бүтээгдэхүүн
Бүтээгдэхүүн

Анхны цагт хүүхдийн байгуулал

БАГАНУУР ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН "ДӨЛ-2022" ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛЛАА

Багануур дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдах Батлан хамгаалахын сайдын нэрэмжит Улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл-2022" цогцолбор тэмцээний 1, 2 дугаар шатны шалгаруулалтыг Багануур дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд 4 дүгээр сарын 01-нээс 29-ний өдрүүдэд зохион байгуулж явуулсан.

Нэгдүгээр шатны шалгаруулалтыг Ерөнхий боловсролын 4 сургууль дотооддоо 10, 11 дүгээр ангийн 23 бүлгийн нийт 669 хүүхдийг хамруулан 04 дүгээр сарын 25-ны дотор зохион байгуулж, дүүргийн аварга шалгаруулах хоёрдугаар шатны тэмцээнд оролцож баг тамирчдыг сонгон шалгаруулсан.


Дүүргийн Засаг даргын нэрэмжит дүүргийн аварга шалгаруулах хоёрдугаар шатны шалгаруулалтыг 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр гарааны өмнөх ажиллагааг Д.Нацагдоржийн талбай, маршийн гүйлтийг Хилийн цэргийн 0252 дугаар ангийн сургалтын хотхонд амжилттай зохион байгуулж, шилдгүүдээ тодрууллаа.

Дүүргийн аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл-2022" тэмцээний нээлтийн ажиллагаанд дүүргийн Засаг дарга С.Даваасүрэн, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт шинжилгээ хариуцсан ахлах офицер, хурандаа М.Мөнгөтулга, дүүргийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, Ерөнхийн боловсролын сургуулийн захирлууд хүрэлцэн ирж, тэмцээнд оролцож байгаа баг тамирчдад амжилт хүссэн юм.

Хоёрдугаар шатны шалгаруулалтад 4 сургуулийн 4 багийн нийт 70 гаруй сурагч, багш дасгалжуулагч нар оролцож, авхаалж самбаа, авьяас чадвараа сорин өрсөлдлөө.

Дүүргийн аварга шалгаруулах "Дөл-2022" тэмцээний тэргүүн байрт Боловсрол цогцолбор сургуулийн "Соёмбо-3" тасаг, дэд байрт Оюуны эрин цогцолбор сургуулийн "Сүлд" тасаг, гутгаар" байрт Гүн галуутай цогцолбор сургуулийн "Одхүү" тасаг тус тус шалгарсан.

Тэмцээний "Шилдэг тамирчин сурагч"-аар Оюуны эрин цогцолбор сургуулийн 113 ангийн сурагч М.Тэмүүлэн, Гранат шидэлтийн төрөлд Гүн галуутай цогцолбор сургуулийн 104 ангийн сурагч Н.Тэмүүлэн, Галын бэлтгэлийн нормативын төрөлд Боловсрол цогцолбор сургуулийн 114 ангийн сурагч А.Халиунзаяа, Гэрэлт ирээдүй МСҮТ-ийн нэгдүгээр курсийн сурагч Э.Мөнх-Очир нар шалгарч бусдыгаа тэргүүлсэн.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,273,004 /69.9%/	2,175,662 /66.9%/	1,040,412 32,0%
		125,447 /3,9%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 8466 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 7	ЭДГЭРСЭН 8338
------------------------------	--------------------------	------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 513,942,811
Эдгэрсэн Нийт: 468,364,428
Нас барсан Нийт: 6,263,214

Цахим шууданд

ЦЭРЭГЖЛИЙН ДӨРВӨН ТӨРӨЛТИЙН АВАРГУУД ТОДОРЛОО



Зэвсэгт хүчний 2022 оны Цэрэгжлийн дөрвөн төрөлтийн аварга шалгаруулах тэмцээн Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд амжилттай зохион байгуулагдлаа. Зэвсэгт хүчний 33 нэгтгэл, ангийн 300 гаруй баг тамирчид цэрэгжлийн буудлага, саадын зурвас, мэргэн буудагчийн хоёр төрөлтөөр өрсөлдөж, аваргуудаа тодруулав. "Цэрэгжлийн буудлага"-ын автомат буудлагын төрөлд

мастер, хошууч М.Хишгээ (345), дэд байрт ахлах ахлагч Г.Золжаргал (350), гутгаар байрт ахлагч Б.Оюунчимэг (310) нар шалгарав.

Гар бууны тогтоол буудлагын төрөлд эрэгтэйчүүдээс тэргүүн байрт хурандаа Х.Баньд (ЗХЖШ), дэд байрт дэд хурандаа Д.Сүхбат (256), гутгаар байрт цэрэгжлийн спортын мастер, ахмад Б.Цээноров (350), эмэгтэйчүүдээс тэргүүн байрт ахлах дэслэгч Б.Оксана (110),

Эрдэнэ (256), дэд байрыг олон улсын хэмжээний мастер, ахлагч А.Пүрэвбаатар (065), гутгаар байрыг тэргүүн ахлагч Б.Баттулга (032) нар эзэлж, эмэгтэйчүүдээс тэргүүн байрт ахмад Х.Нандин-Эрдэнэ (338), дэд байрт цэрэгжлийн спортын мастер, дэд хурандаа Д.Тунгалаг (ЗХЖШ), гутгаар байрт ахмад Б.Хандсүрэн (330) нар шалгарав.

Багийн дүнгээр эрэгтэйчүүдийн төрөлд тэргүүн байрт дэд хурандаа М.Гүрбадам захирагчтай Зэвсэгт хүчний 256 дугаар анги, дэд байрт хурандаа Д.Шинэбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 084 дүгээр анги, гутгаар байрт хурандаа Ж.Мөнхбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 032 дугаар анги тэргүүлсэн бол эмэгтэйчүүдийн төрөлд багийн дүнгээр тэргүүн байрт ЗХЖШ-ын баг, дэд байрт хурандаа Н.Бат-Эрдэнэ захирагчтай Зэвсэгт хүчний 330 дугаар анги, гутгаар байрт хурандаа Ж.Мөнхбаяр захирагчтай 032 дугаар ангийн баг тамирчин тус тус шалгарав.

Биатлоны төрөлд нэгдүгээр байрт цэрэгжлийн спортын мастер, ахлагч Ө.Отгонбаатар (350), хоёрдугаар байрт ахмад Б.Ариунболд (016), гуравдугаар байрт ахлагч П.Элбэгдорж (327) нар шалгарсан бол Патрулийн төрөлд Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн ахмад Д.Цолмон, ахлагч Б.Булганбаяр, цэрэгжлийн спортын мастер, ахлах ахлагч Б.Баасандорж, цэрэгжлийн спортын мастер, ахлагч А.Алтансүх нарын баг тэргүүн байрт, Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн ахлах дэслэгч Ж.Дулаанжаргал, дэслэгч С.Идэрболд, ахлагч П.Элбэгдорж, ахлах ахлагч П.Төрболд нарын баг дэд байрт, Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн цэрэгжлийн спортын мастер, ахмад

Б.Цээноров, цэрэгжлийн спортын мастер, ахлагч Ө.Отгонбаяр, цэрэгжлийн спортын мастер, ахлах ахлагч А.Амаржаргал, дэд ахлагч Н.Мөнгөншагай нарын баг гутгаар байрт шалгарав.

Биатлоны багийн дүнгээр Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн цэрэгжлийн спортын мастер, ахлагч Ө.Отгонбаяр, цэрэгжлийн спортын мастер, ахмад Б.Цээноров нар тэргүүн байрт, Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн ахлагч Н.Гантулга, ахлагч Б.Нямлхагва нар дэд

зурвас"-ын тэмцээнд эрэгтэй офицерын төрөлд ахлах дэслэгч Б.Төвжаргал (016), ахмад Б.Ариунболд (016), ахмад Б.Даваадорж (016), эмэгтэй офицерын төрөлд дэслэгч Ц.Дондогдулам (065), дэслэгч У.Энх-Оюун (310), дэслэгч Ч.Отгонбаяр (325) нар эхний байруудыг эзэллээ. Ахлагчийн төрөлд эрэгтэйчүүдээс цэрэгжлийн спортын мастер, ахлагч А.Алтансүх (084), ахлагч П.Элбэгдорж (327), дэд ахлагч Б.Олзэмх (150), эмэгтэйчүүдийн төрөлд дэд

хүчний 065 дугаар анги, дэд байрыг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, гутгаар байрыг Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн баг тамирчид эзэллээ.

Ингээд байгууллагын дүнгээр эрэгтэй баг тамирчдын төрөлд тэргүүн байрт хурандаа Ш.Цэрэнбат захирагчтай Зэвсэгт хүчний 065 дугаар анги, дэд байрт хурандаа Ц.Буянжаргал захирагчтай Зэвсэгт хүчний 311 дүгээр анги, гутгаар байрт бригадын генерал Т.Лодойдамба захирагчтай Зэвсэгт хүчний 016 дугаар



эрэгтэйчүүдээс тэргүүн байрт ахлах ахлагч Т.Цог-Эрдэнэ (310), дэд байрт ахлах ахлагч С.Цолмонбаяр (311), гутгаар байрт сургагч ахлагч Г.Хатанбаатар (084), эмэгтэйчүүдээс тэргүүн байрт цэрэгжлийн спортын

дэд байрт дэслэгч О.Өлзий-Орших (334), гутгаар байрт дэслэгч Н.Ууганцэцэг (013) нар шалгарч, бусдыгаа тэргүүллээ.

Хурдан буудлагын төрөлд эрэгтэйчүүдээс тэргүүн байрыг ахлах дэслэгч Ч.Бат-

байрт, Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн цэрэгжлийн спортын мастер, ахлагч Б.Батжаргал, цэрэгжлийн спортын мастер, ахлагч А.Алтансүх нар гутгаар байрыг эзэлж, байгууллагын дүнгээр тэргүүн байрт Зэвсэгт хүчний 084 дүгээр анги, дэд байрт Зэвсэгт хүчний 350 дугаар анги, гутгаар байрт Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн баг тамирчид шалгарсан юм. Тэгвэл "Саадын

ахлагч С.Нандин-Эрдэнэ (350), ахлагч Э.Ариунтулгалаг (011), спортын мастер, ахлагч Э.Ариунзул (311) нар эхний гурван байрт шалгарлаа.

Эрэгтэй буухиа төрөлд тэргүүн байрт Зэвсэгт хүчний 120 дугаар анги, дэд байрт Зэвсэгт хүчний 084 дүгээр анги, гутгаар байрт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн баг тамирчид шалгарч, эмэгтэйгүүдийн буухиад тэргүүн байрыг Зэвсэгт

нэгтгэлийн тамирчид, эмэгтэй баг тамирчдын төрөлд бригадын генерал Т.Лодойдамба захирагчтай Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, дэд хурандаа Б.Олзбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 150 дугаар анги, хурандаа Н.Цэцэнхүү захирагчтай Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн баг тамирчид эхний гурван байрт шалгарсан юм.

ШИНЭ ЦЭРГҮҮД МОД ТАРИВ



Хэнтий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб Хэнтий аймгаас 2022 оны 1 дүгээр ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан залуучуудыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн

санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих арга хэмжээнд оролцууллаа. Шинээр цэргийн албанд татагдаж байгаа залуучууд нийт 200 гаруй мод тарих нүх бэлтгэн 100 гаруй мод тарилаа. Тус арга хэмжээнд

шинээр цэргийн албанд татагдаж байгаа залуучуудын ар гэрийн төлөөлөл оролцсон бөгөөд урд нь өмнө нь ийм арга хэмжээ зохион байгуулж байгаагүй шинэлэг зүйл боллоо гэцгээж байлаа. Энэхүү арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөж байна.

"ТЭРБУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД ХАМРАГДЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачилгаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг Улс орон даяар өрнүүлээд байна. Энэхүү үндэсний хөдөлгөөнийг Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний нийт бүрэлдэхүүн идэвхтэй дэмжиж, мод тарих, ургуулах, арчлан хамгаалах ажлыг амжилттай гүйцэтгэж эхэлсэн. Уг хөдөлгөөнд

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 305 дугаар тусгай салбарын бие бүрэлдэхүүн хамрагдаж, "Булган-Өгөөж" ХХК-тай хамтран Ховд аймгийн Булган суманд 1200 ширхэг алимны модыг тарих, суулгах ажлыг 3 өдрийн хугацаанд хэрэгжүүллээ. Цаашид уг моднуудыг арчлан ургуулах ажилд 305 дугаар тусгай салбарын хамт олон хамтран ажиллах юм.

РАДИОТЕХНИКИЙН МЭРГЭЖЛЭЭР ТӨГСӨГЧИД ВОЛЕЙБОЛООР ӨРСӨЛДӨВ



Агаарын цэргийн командлал ҮБХИС-ийн Агаарын цэргийн тэнхимийн 30 жилийн ойд зориулан Р а д и о т е х н и к и й н мэргэжлийн анхны төгсөгчдөөс санаачлан р а д и о т е х н и к и й н мэргэжлийн багш, төгсөгчдийн дунд волейболын тэмцээн 4 дүгээр сарын 24-ний өдөр Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн байрлалдамжилттай болж өндөрлөлөө. Үе үеийн төгсөгчдөө хооронд нь танилцуулах, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, харилцан туршлага

солилцох зорилгоор зохион байгуулсан тус тэмцээнд нийт 15 багийн 120 гаруй тамирчид хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс дэд хурандаа Г.Баатархүү ахлагчтай 2004 оны төгсөгчид I байр, хурандаа Ч.Буянзаяа ахлагчтай 2001 оны төгсөгчид II байр, хошууч Г.Ууганбаатар ахлагчтай 2009 оны төгсөгчид III байр, бэлтгэл хурандаа Ү.Амгаланбаатар ахлагчтай 1996 оны төгсөгчид IV байрыг тус тус эзэллээ. Тэмцээний шилдэг довтлогчоор хошууч Б.Энхболд /2004/, шилдэг

холбогчоор дэд хурандаа Л.Эрдэнэбилэг /1996/, шилдэг тэгш тоглогчоор дэд хурандаа С.Алтай /2001/ нар шалгарав. Мөн энэ үеэр үе үеийн төгсөгчид Агаарын цэргийн тэнхимийн анхны багш, рот, курсийн захирагч нартаа хүндэтгэл үзүүлж, радиотехникийн мэргэжлийн төгсөгчдөөс төрөн гарсан хурандаа нарт дурсгалын зүйлийг гардуулан өглөө. Энэхүү нөхөрсөг тэмцээн нь жил бүр уламжлал болгон зохион байгуулагдах бөгөөд ирэх жилийн тэмцээнийг 1997 оны төгсөгчид зохион байгуулахаар боллоо.